



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 542

Улаанбаатар хот

“Сэлэнгэ Дулаанхан” ХК-ийн үнэт цаасны  
арилжааг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Сэлэнгэ Дулаанхан” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. “Сэлэнгэ Дулаанхан” ХК-ийн хувьцааг арилжаалж эхлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д, үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000872